



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

ГХөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "л", Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, мөн оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.
2. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
3. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг аргазүйн нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн комиссын дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03
дугаар сарын 22-ны өдрийн А/91
дугаар захирамжийн хавсралт



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:

М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Комиссын орлогч дарга:

Б.Базардамбуу (Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Базар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Цолмонбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа,
үйлчилгээний албаны дарга)

Б.Бямбасүрэн (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал, үржлийн албаны дарга)

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
дарга)

Р.Отгонцэцэг (Статистикийн хэлтсийн мэдээлэл технологи хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Т.Алтанцэцэг (Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

---oOo---